



Хичээлийн
хэрэгслээ
бэлтгээрэй.

Анхаарч
сонсоорой.


Сурах
бичгийнхээ 47-
р хуудас

Дэвтэрт
тэмдэглэл
хөтлөөрэй.

Хичээллэх
орчноо
бүрдүүлээрэй.

Дэлхийн 2-р дайны үеийн БНМАУ

- ❑ Зөвлөлтийн ард түмэнд тусалсан нь
- ❑ Дайны үеийн эдийн засаг, соёл
- ❑ БНМАУ улс Японы эсрэг дайнд оролцсон нь





Хичээлийн сэдэв:

БНМАУ-ын тусгаар тогтнолын бэхжилт

Ялтын бага хурал: БНМАУ-ын статус кво

Бүх ард түмний санал хураалт

БНМАУ НҮБ –ын гишүүн болов.



Хичээлийн зорилго




БНМАУ-ын тусгаар тогтнолын бэхжилттэй холбоотой гол үйл явдлуудын талаар мэдлэг, ойлголтоо гүнзгийрүүлж, он дарааллын бичиг үйлдэж, түүнийгээ оновчтой тайлбарлах чадвартай болно.





Ялтын бага хурал



1945 оны II сард Ялтад хуралдсан ЗХУ, АНУ, Их Британийн Засгийн газрын тэргүүн нарын бага хурал дэлхийн II дайныг төгсгөж, даян дэлхийд энх тайван байдал тогтооход чухал ач холбогдолтой болжээ.

Тус бага хурал дээр Европт дайн дууссанаас хойш 3 сарын дараа ЗХУ Японд дайн зарлах тухай асуудал ба түүнтэй холбоотой болзлуудыг харилцан тохиролцсон байдаг.

ЗХУ-ын саналыг хүлээн авч БНМАУ-ын статус квог хэвээр үлдээнэ гэж тохирчээ. Энэхүү шийдвэрийг Чан Кайшид ойлгуулах үүргийг Франклин Рузвельт хүлээв.



Raydangiin БАЯАР

ЗХУ-д албан ёсны айлчлал хийхээр хүрэлцэн ирсэн БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсанд гадаад улсын төр, засгийн тэргүүн нарын хэмжээнд угтан авчээ, 1945.07.05.



Бүх ард түмний санал хураалт



1944 онд 07.13-нд АНУ-ын дэд ерөнхийлөгч ноён Хенри Уоллес, монголч эрдэмтэн О. Латтимор нарын хамт Улаанбаатар хотод хүрэлцэн ирэв.

И. Сталин “Хэрэв БНМАУ-ын тусгаар тогтнолыг Хятад улс хүлээн зөвшөөрөхгүй бол бид Японтой байлдах үүргээ биелүүлэхэд бэрхшээлтэй болно”

1945. 08.14-нд 2 тал хэрэв БНМАУ-ын хүн ам тусгаар тогтнох эрмэлзлэлээ баталбал Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь хүлээн зөвшөөрнө гэсэн ноот бичиг солилцсон байна.

УБХ-ын тэргүүлэгчид 1945.09.21-нд уг ноот бичгийг хэлэлцэж, БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудлаар 10.20-нд орон даяар санал хураалт явуулахаар тогтжээ.



Санал хураалтад зориулсан ухуулгын зурагт хуудаст “Би [Бүгд Найрамдах Монгол Ард Улсын](#) харьяат мөн. Хүн болж төрсний минь дээд зэргийн эрхэм эрмэлзэл бол өөрийн эх орны тусгаар тогтнолын төлөө амь ба санаа сэтгэлээ зориулахад хэзээ ч бэлхэн байхад оршино. Би өөрийн харьяат эх орны тусгаар тогтнолын төлөө батална” хэмээн бичиж, дэвсгэрт нь Монголын газрын зургийг байрлуулан, гараа өргөн санал өгч буй хүнийг дүрсэлсэн байдаг. Энэ түүхэн баримт өдгөө Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагддаг.



Санал хураалтын төв комиссыг УБХ-ын тэргүүлэгчдийн дарга Г. Бумцэндээр даргалуулсан байна. Санал хураалт өглөө 6 цагт эхэлж, сумын төвд үдийн 12 цаг, аймгийн төвд орой 8 цаг хүртэл ажиллав.



Бүх ард түмний санал хураалт



Ард нийтийн санал хураалтад тус улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн 98.4 хувь нь оролцож цөм төрийнхөө тусгаар тогтнолыг нэгэн дугаар баталсан юм.

Санал хураалтыг ажиглахаар Хятадын Засгийн газрын Дотоод яамны орлогч сайд Ли Фин Цзянь тэргүүтэй төлөөлөгчид ирж оролцжээ.



Бүх ард түмний санал хураалт



1946 оны 01 сарын 05-нд ДИУ-ын засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрснөө зарласан байна. 02 сарын 13-нд дипломат харилцаа тогтоожээ.

1946 оны 3 сард ДИУ-ын Засгийн газрын урилгаар Сайд нарын зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга Ч. Сүрэнжав тэргүүтэй төлөөлөгчид очсон байна.



Монгол Улс НҮБ-д элссэн нь



НҮБ-ын дүрмийг зөвшөөрч түүний гишүүн орон болох хүсэлтээ БНМАУ 1946 оны 6-н сард гаргасан юм. Гэвч 15 жилийн турш НҮБ-д элсэж чадаагүйн учир юу вэ?




Тайвань болон түүнийг ивээн дэмжигч өрнөдийн зарим улс БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөхгүй ЗХУ-ын дагуул орон, гадаад бодлогын туршлага, дадлагагүй, энх тайванч бус



Монгол Улс 1961 оны 10 сарын 27-нд БНМАУ НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болжээ.



Монгол Улс НҮБ-д элссэн нь



НҮБ -ын гишүүн болгоход нэр их хөдөлмөр үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүс.

Нэрт дипломатчид.1961 он.

Гадаад Явдлын Яамны орлогч сайд Д.Цэвэгмид, Элчин сайд Б.Жаргалсайхан, Гадаад Явдлын Яамны хэлтсийн эрхлэгч Б.Дашцэрэн, О.Дамдиндорж нар.



Монгол Улс 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсны дараа туг мандуулах ёслолын үеэр.

Монгол Улс НҮБ-д элссэн ач холбогдлыг Монгол Улсын ГХЯ-ны сайд асан Ц.Гомбосүрэн ингэж дүгнэж байжээ:

Монгол Улс тусгаар тогтнолоо зарласнаас хойш гол тэмцсэн асуудал бол тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх байлаа. Хятадаар хүлээн зөвшөөрүүлэх гэж 25 жил болсон. ЗХУ 1921 онд Ардын засгийн газрыг хүлээн зөвшөөрсөн. 1924 оны 11 дүгээр сарын 26-нд Бүгд Найрамдах Монгол Улсыг тунхагласан. Гэтэл 1924 оны 5 дугаар сард байгуулсан Орос, Хятадын харилцааны зарчмын тухай гэрээнд Монгол бол Хятадын салшгүй хэсэг гэж бичсэн байдаг. Энэ гэрээ 1946 он хүртэл хүчин төгөлдөр байлаа. Тэгэхээр ЗХУ, Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь олон улсын эрх зүйн үүднээс үзэхэд тодорхой биш байсан юм. Харин Дэлхийн II дайны дараа 1945 онд дэлхий дахины байдал өөр болсон... НҮБ-д элсэж тусгаар тогтнолоо дэлхийн хэмжээнд баталгаажуулна гэдэг үнэхээр чухал үйл явдал байсан гэжээ.

БНМАУ-ын тусгаар тогтнолын бэхжилт

1. Ялтын бага хурал: БНМАУ-ын статус кво
2. Бүх ард түмний санал хураалт
3. Монгол Улс НҮБ-д элссэн нь





Бататгал 1:

1945 оны 10-р сарын 20-ны өдөр болсон бүх ард түмний санал хураалт ямар асуудлаар болсон бэ?

- A. НҮБ-д элсэх эсэх асуудлаар
- B. Монгол улсын тусгаар тогтнолын асуудлаар
- C. Үндсэн хуулийн бүх нийтийн хэлэлцүүлгийн асуудлаар
- D. Хөдөө аж ахуйн нэгдэл байгуулах асуудлаар
- E. Чөлөөлөх дайнд оролцох эсэх асуудлаар



Бататгал 2:

Монгол улсын тусгаар тогтнолын төлөөх бүх нийтийн санал асуулга хэдэн онд болсон бэ?

- A. 1989 он B. 1961 он C. 1960 он D. 1945 он E. 1992 он



Бататгал 3:

БНМАУ-ын статус квог хадгалах асуудлыг хэлэлцсэн Ялтын бага хурал хэдэн онд болсон бэ?

- A. 1946 он B. 1961 он C. 1951 он D. 1959 он E. 1945 он




Бататгал 4:

1945 оны II сард ЗХУ, АНУ, Их Британи улсын тэргүүнүүд уулзаж Гадаад Монголын статус квог Хятадын засгийн газраар хүлээн зөвшөөрүүлэх үүргийг аль улсын хэнд хүлээлгэсэн бэ?





- A. ЗХУ-ын удирдагч И.В.Сталин
- B. Германы канцлер А.Гитлер
- C. Их Британийн ерөнхий сайд У.Черчилль
- D. АНУ-ын ерөнхийлөгч Г.Трумэн
- E. Италийн удирдагч Б.Муссолини




Гэрийн даалгавар



- Та бүхэн сурах бичгийнхээ 47-р талд буй мэдээллийг сайтар уншаарай.
- Мэдээллийг унших явцдаа гол ойлголтуудыг тэмдэглэж аваарай.
 - Сурах бичгийн асуулт даалгаврыг гүйцэтгээрэй.
 - Тухайн сэдвийн хүрээнд сонирхсон асуудлаа тодруулж оюуны зураглал хийгээрэй.





АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА.